

**МОНГОЛ ХЭЛНИЙ ҮГИЙН ЖУРАМЛАХ, ХУВИЛБАР,  
БУРУУ ДУУДЛАГА ҮҮСЭХ АСУУДАЛД**

**О. Самбуудорж\***

*Түлхүүр үгс: Монгол хэл, журамлах дуудлага, хувилбар дуудлага, хэлний хувьсал*

**1. Удиртгал.** Монгол хэлний үгийн олон дуудлага үүсэх асуудлыг өнөө хэр нарийвчлан судлаагүй байдаг. Зарим судлаачид “Хааны бичсэн манж, монгол үгний толь бичиг”-ийг монгол хэлний үгийн дуудлагыг тэмдэглэхэд чиглэсэн анхны бүтээл гэж үзэж байна [8]. Тухайн бүтээлд монгол хэлний зарим үгийн дуудлагыг манж хэлний цагаан толгойн үсгээр яаж дуудахыг тэмдэглэсэн байдаг. Монгол хэлний сурах бичиг, авиан зүйн судалгааны бүтээлүүдэд авиаг хэрхэн дуудах, бичих талаар нэлээд зүйл өгүүлсэн байдаг байна [6,7,10, 11, 12, 15,17].

Түүнчлэн монгол хэлний толь бичгүүдэд нэг үгийн олон дуудлага, бичлэгийг анхаарсаар ирсэн байна. Тухайлбал, Я.Цэвэл гуай монгол хэлний тайлбар толийн удиртгалд “...нэг үгийн янз янз бичлэгийн аль алины нь оруулсан болно” [16:5] гэж өгүүлж байна. Манай нэртэй эрдэмтэн Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв нар Орос-Монгол толины өмнөх үгэнд “Монгол шинэ бичгийн хэлэнд нэгэн мөр болж чадаагүй олон янзаар бичих, дуудах үг нэлээд байдаг. Энэ явдал манай толь бичигт бас нөлөөллөө. Жишээлбэл: эгэм-ээм, чацуу-чуцуу-сацуу... Цаашид эдгээр үгийн зарим нь нэгэн мөр бичлэгтэй болох ба зарим нь өөр бичлэгтэй, өөр утгатай болж хөгжих бололтой” [5:3] гэж өгүүлж байна.

Эрдэмтэн М.Базаррагчаа орос хэлний зөв дуудах зүйд ямар чухал зүйл байдгийг өгүүлээд “Тэгвэл манай зөв дуудах зүйн чухал зүйл юу вэ гэвэл, бидний бодож байгаагаар, 1. Балархай эгшгийг дуудах дүрэм 2. Тагнайшсан гийгүүлэгчийг дуудах дүрэм болно” гэж байна [3:29]. Бид хэлэхүйн соёлд үгийн дуудлагыг журамлах, хувилбар, буруу дуудлага гэж ангилах зарчмыг баримтлах нь зүйтэй гэж үзэж байгаа билээ [13]. Иймд энэ өгүүлэлд бид тухайн дуудлагуудын ялгаа, үүсэх шалтгааны талаар товч өгүүлнэ.

**2. Журамлах, хувилбар, буруу дуудлага.** Ажиглалтаас үзэхэд орчин цагийн монгол хэлэнд нэг үгийг 1-ээс 10-аад янзын хувилбараар дуудах тохиолдол цөөнгүй байгаа юм. Хэрэв үүн дээр өгүүлэгчийн өгүүлэхүйн болон сэтгэлийн хөдөлгөөнтэй холбоотой үүсэх үгийн өнгө, аялгыг нэмбэл бүр олон хувилбар дуудлага үүсч болдог. Тухайлбал, бид яриандаа хамгийн давтамжтай

\* Шинжлэх Ухааны Академи, Хэл Зохиолын Хүрээлэн

## О. Самбуудорж

хэрэглэдэг “**тийм [ti:m] (Yes, I see)**” гэдэг үгийг бараг 10 гаруй хувилбараар “**тийм, тийн, тээн, тий, тээ, ти, тэ, ти-э, тх [ti:m, ti:n, te:n, ti:, te:, ti, te, ti-e, th]**” гэх мэтээр дууддаг. “Энэ” хэмээх заах төлөөний үгийг харьялахын тийн ялгалд “**энэ, энэний, эний, үүний**” гэх мэтээр дуудах нь бий. Үүнээс үзвэл, хэлэхүйн хурд, хэлний хувьсал, утга илэрхийлэх зэргээс хамаарч нэг үгийн хэд хэдэн дуудлага хэлэнд бий болдог байна.

Хэлний бүтэц, тогтолцооны ерөнхий хэм хэмжээг тусгасан, хүмүүс ингэж дууддаг гэдгийг мэддэг, хүлээн зөвшөөрсөн дуудлагыг “**журамлах дуудлага**” (*standart/correct pronunciation*), хүмүүс одоохондоо хүлээн зөвшөөрөх хэмжээнд хүрээгүй боловч хэлний бүтэц, тогтолцооны хэм хэмжээний хүрээнд хувьсан өөрчлөгдөж буй дуудлагыг “**хувилбар дуудлага**” (*variation pronunciation*), хүмүүс хүлээн зөвшөөрөх дургүй байгаа буюу хэлний бүтэц, тогтолцоог анхаарч хайхраагүй дуудлагыг “**буруу дуудлага**” (*wrong pronunciation*) гэж болно. Үүнээс шалтгаалан үгийн дуудлагыг журамлах дуудлага, хувилбар дуудлага, буруу дуудлагууд гэж хувааж болох ба эдгээр дуудлага нь авианы найруулга, хэрэглэх давтамжаараа бие биеэсээ ялгарч байдаг байна. Жишээ нь:

Журамлах дуудлага	Хувилбар дуудлага	Буруу дуудлага	Буруу дуудлагын шалтгаан
шаргуу	шургуу	ширгуу	Авианы буруу байрлал
хэрэв, хэрвээ	хэрвээ	хирэв	Авианы буруу байрлал
үүнээс	энэнээс, энээс	инээс, инайс	Авианы буруу байрлал
даалгавар	даалгуур	даалгар	Үгийг бүрэн бус дуудсан
тийм	тий, тээ, тийн	тиэ, тх	Үгийг бүрэн бус дуудсан
нэгдүгээр	- . -	нэгдугаар	Авианы буруу байрлал
танд	- . -	таньд	Хэлзүйн буруу хэлбэр
тан руу	- . -	тань руу, тан луу	Хэлзүйн буруу хэлбэр

**3. Үгийн олон дуудлага үүсэх нь.** Монгол хэлэнд заримдаа нэг үгийн хоёр буюу хэд хэдэн хувилбар дуудлага бий болдог нь ихэнхдээ үгийг бүрэн, бүрэн бус дуудахтай холботой боловч, эх болон шинэ дуудлагыг хослуулан хэрэглэх, нутгийн аялгажуулах, харь хэлнээс үг зээлэх, хувь хүний өгүүлэхүйн онцлог, бичгийн болон ярианы хэлний дуудлага зэрэгтэй холбоотой байдаг байна [14]. Жишээ нь:

**3.1. Бүрэн ба бүрэн бус дуудлага.** Тухайн үгийн авиа, үеийг үл орхин хэлэхийг үгийн бүрэн дуудлага гэнэ. Тухайн үгийн аль нэг авиа, үеийг орхиж дуудахыг үгийн бүрэн бус дуудлага гэнэ [1]. Үгийг бүрэн, бүрэн бус дуудах нь найруулгын **эрхэмсэг яриа** (дээд), **энгийн яриа** (дунд), **жир бус яриа** (доод) гэсэн ялгааг бий болоход нөлөөлж байдаг байна. Жишээ нь:

Бүрэн дуудлага		Бүрэн бус дуудлага
Эрхэмсэг ярианы дуудлага	Энгийн ярианы дуудлага	Жир бус (хар) ярианы дуудлага
даалгавар	даалгавар, (даалгуур)	даалгар
өчигдөр	өчигдөр, өцөгдөр	өчдөр, өцдөр
жа	за	(за)
тийм	тийм, тийн, тий, тээ	ти, тэ, тх
байна шүү дээ	байна шүү дээ	вайнаштээ
байж байна	байж вайна	вайжайна
байдаг юм	байдаг юм, байдаг им	байдгийм, вайдийм

## О. Самбуудорж

**3.2. Эх ба үүсмэл дуудлага.** Монгол хэлэнд үгийн эх, үүсмэл, үүсч буй дуудлага нь үгийн авианы дуудлагатай холбоотой төдийгүй, бүтээврээр илэрч байдаг байна. Жишээ нь:

Эх дуудлага	Үүсмэл дуудлага	Утга
өвөр (зуураа)	өөр (зуураа)	бие хоорондоо
эгүүдэн	үүдэн	шалтгаалан
жа	за	зөвшөөх аялга
хэн буй	хэн бэ	асуух үг
агсан	асан	туслах үйл үг
мэдэхүй	мэдэх	ойлгох, ухаарах

**3.3. Бичгийн хэлний болон нутгийн аялгууны дуудлага.** Нутгийн аялгуу нь аль ч хэлний баялаг түүхийг харуулж байдаг. Зарим бичгийн хэл нь хотын, бүс нутгийн гэх мэт хэд хэдэн дуудлагатай байдаг байна. Орос бичгийн хэлэнд Москвагийн, Санкт-Петербургийн гэсэн хоёр дуудлага голлох үүрэгтэй байдаг байна [4]. Япон хэлний үгийн дуудлагад Токиогийн, Осакагийн гэсэн дуудлага нэлээд үүрэгтэй байдаг байна. Ажиглалтаас үзвэл Улаанбаатар хотын оршин суугчдын хэл ярианд төв халхын аялгуу зонхилж, ойрд болон бусад аялгуунууд дагалдах үүрэгтэй байдаг. Жишээ нь:

Бичгийн хэл (Төв аялгууны дуудлага)	Нутгийн аялгууны дуудлага	Аль аялгуу
хот	гот	Халхын салбар аман аялгуу
тарвага	таварга	Халхын салбар аман аялгуу
муруй	мурий	Халхын салбар аман аялгуу
өвдөх	өвсөх	Халхын салбар аман аялгуу
манай	манаа	Ойрдын аман аялгуунууд
дээл	дэвэл	Ойрдын аман аялгуунууд
жаргал (жыргал)	жиргал	Ойрдын аман аялгуунууд
сайн	хайн	Буриадын зарим аялгуунууд
дээл	дэгэл	Буриадын зарим аялгуунууд
цагаан	сагаан	Буриадын зарим аялгуунууд
зам	жам	Өвөрлөгчдийн зарим аялгуунууд
цагаан	чагаан	Өвөрлөгчдийн зарим аялгуунууд

**3.4. Этгээд дуудлага.** Монгол хэлний үгийн этгээд дуудлага нь үгийн авиаг болон үгийг сольж хэлэх зэргээр илэрдэг байна. Жишээ нь:

Энгийн дуудлага	Этгээд дуудлага	Шалтгаан
маш гоё	зэрлэг гоё	Үгийг сольсон
ерөнхийлөгч	еөгий	Үгийг хураасан
цагдаа	гацдаа	Авиаг тонгоргон, утгыг далдалсан
шил архи	шаг	Үгийг хурааж, утгыг далдсан

**3.5. Илт буруу дуудлага.** Эх хэлнийхээ авианы байрлал, үеийн бүтэц, бичгийн болон ярианы хэлний ялгааг анхааралгүй дуудахыг үгийн илт буруу дуудлага гэж болно. Монгол хэлэнд орсон харь үгийн дуудлага нь аман болон бичгийн хэлээр дамжин орж ирсэн хоёр онцлогтой бөгөөд бичгийн хэлээр дамжин орж ирсэн үгс ч яваандаа ярианы хэлний дуудлагатай болж, бичлэг нь дуудлагаа даган өөрчлөгдөж ирсэн байдаг [9]. Жишээ нь:

О. Самбуудорж

Бичгийн хэл	Буруу дуудлага	Зөв дуудлага
авга	авга	авага
ботго	ботго	ботого
сурталчлах	сурталчлах	сурталчилах
хаврын	хаврын	хаварын
сонсох	сонсох	соносох
улс	улс	улас
дараах	дараах	дараахь
олонх	олонх	олонхи
дасгал	дасгал	дасхал
тусгай	тусгай	тусхай
хоржигнох	хоржигнох	хоржигинох
трактор	трактор	тараахтар
рашаан	рашаан	аршаан

**3.6. Хувь хүний дуудлага.** Ийм дуудлага нь ихэнхдээ хувь хүний өгүүлүүрийн бааз, ярих хэв маягтай холбогдож байдаг. Жишээ нь:

Нийтийн дуудлага	Хувь хүний дуудлага	Шалтгаан
биз дээ	бид дээ	Авиаг ижилсүүлсэн
голдуу	голцуу, голсуу	Авиаг шүргүүлсэн
тийм, тийн	ти, тэ, тх	Бүрэн бус дуудсан
өчигдөр	өчдөр, өцдөр	Бүрэн бус дуудсан

**4. Дүгнэлт.** Бидний энд өгүүлсэн зүйлээс үзвэл монгол хэлний үгийн дуудлагыг хэлний тогтолцооны талаас журамлах, хувилбар, буруу дуудлага гэж гурван төвшинд ангилан хувааж болно. Дуудлагын эдгээр хувилбарыг хэлний тогтолцооны талаас төдийгүй хэлэхүйн соёл, хүмүүсийн хүлээн зөвшөөрөх сэтгэлзүйн талыг нэгэн адил харгалзах нь чухал байна. Үгийн олон дуудлага нь авианы найруулга болон хэрэглэгдэх давтамжаараа бие биеэсээ ялгарна. Монгол хэлний үгийн олон дуудлага үүсэх шалтгаан, зүй тогтлыг судлах нь:

- Хэлний хувьсал хөгжлийг танин мэдэх,
- Хэлзүйн сурах бичиг зохиох,
- Монгол хэлний заах аргыг боловсронгуй болгох,
- Монгол хэлийг гадаадынханд заах,
- Дуудлагын толь зохиох,
- Зөв бичих дүрмийг боловсронгуй болгох зэрэгт ихээхэн ач холбогдолтой байгаа юм.

## НОМ ЗҮЙ

1. Р.И.Аванесов, Русское литературное произношение. М. 1968. 287 с.
2. Б.Амаржаргал, Г.Гантогтох, Ж.Цолоо, Д.Төмөртогоо, БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг. 1-р боть. Халх аялгууны дуудлагын толь. Уб. 1988. 381-718.
3. М.Базаррагчаа, Зөв дуудах зүй. Уб., 1984. 33 тал.
4. Л.А.Вербицкая, Русская орфоэпия. Лг. 1976. 124 с.
5. Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв, Орос-Монгол толь. Уб. 1982.
6. Ц.Дамдинсүрэн, Б.Осор, Монгол үсгийн дүрмийн толь. Уб. 1983. 431 х.
7. Ш.Лувсанвандан, Орчин цагийн монгол хэлний бүтэц. Авиа, авиалбар хоёр нь. Уб. 1967. 130 х.
8. А.Лувсандэндэв, Монгол утга зохиолын хэлний дуудлагын дүрмийн анхны толь. –“Монгол үндэсний утга зохиолын хэл бүрэлдэн тогтсон нь. Уб. 2002. 216-р тал. –“Өвөр монголын Их сургуулийн Эрдэм шинжилгээний сэтгүүл”. 3-р хугацаа. Хөххот. 16-26
9. А.Лувсандэндэв, Гадаад үгийг хэрхэн бичих тухай асуудалд, –“Монгол үндэсний утга зохиолын хэл бүрэлдэн тогтсон нь. Уб. 2002. 303-304, –“Монгол хэл бичгийн зарим асуудал”. Уб. 1959. 68-76
10. С.Мөөмөө, Монгол хэлний авиан зүй. Уб. 1979. 200 х.
11. Ж.Надмид, Ж.Санжаа, Орчин цагийн монгол хэлний авиан зүй. Уб. 1993. 200 х.
12. О.Самбуудорж, Монгол хэлний ойрд аялгууны фонемийн тогтолцоо. Уб. 2002. 175 х.
13. О.Самбуудорж, Хэлэхүйн соёлд үгийн дуудлагыг анхаарах асуудалд. –“Хэлний соёлын тулгамдсан асуудлууд” №3. Уб. 2010. 97-103
14. О.Самбуудорж, Монгол хэлний үгийн олон дуудлага үүсэх асуудалд. –“Хэл зохиол судлал”. Боть III (35). Уб. 2010. 49-55
15. Ж.Цолоо, Орчин цагийн монгол хэлний авианзүй. Уб. 2008. 417 т.
16. Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь. Уб. 1966. 911 х.
17. Jan-Olof Svantesson, Anna Tsendina, Anastasia Mukhanova Karlsson and Vivan Franzen., The Fonology of Mongolian. –Oxford University Press. 2005. 314 pp.
18. 牧村史陽編、大阪ことば事典 2005年3月18日第26刷 発行 (Макимура Шиёо, Осака аялгууны нэвтэрхий толь. 2005.3.18. 26 дахь хэвлэл, Анхны хэвлэл 1984.10.10)

### PROBLEMS IN THE STANDARD, VARIANT AND WRONG PRONUNCIATIONS OF MODERN MONGOLIAN WORDS

The author focuses on analyzing the standard pronunciation of modern Mongolian words. In speaking, one modern Mongolian word has one to ten different pronunciations. Also, there are many variations in pronunciation due to such factors as intonation and tone. The author considers the different pronunciations of a word to depend on:

1. Use of an archaic form beside new form
2. Dialect
3. Slang/innovation
4. Unfamiliarity with the word
5. Pronunciation by hearing
6. Individual features (Idiolect)
7. Language change in progress

### О. Самбуудорж

Therefore the author divided the pronunciation of modern Mongolian words into three types: standard pronunciation, variant pronunciation and wrong pronunciation. For example:

Standard pronunciation	Variant pronunciation	Wrong pronunciation	Meaning
шаргуу	шургуу	- . -	Persistent(ly), hard
хэрэв	хэрвээ	- . -	If
намайг	надыг	- . -	Me
даалгавар	даалгуур	даалгар	Task, homework
голдуу	- . -	голцуу	Mainly, mostly
танд	- . -	таньд	For you
нэгдүгээр	- . -	нэгдугаар	First

He considered it significant to ascertain the standard pronunciation of Mongolian for:

1. Mongolians to study right speaking (orthoepy) in Mongolian
2. Teaching Mongolian to foreigners
3. Composing a Mongolian orthographic *dictionary, with complete indication of pronunciations*
4. Identifying phonetic evolution and development of Mongolian